БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Алтай сумын эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БӨА-2025/041/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn

Өлгий хот

2025 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын, дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл
Утас:70422954 Цахим хаяг: aigul@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек
Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Лайт энд Дилайт Аудит ХХК-ийн захирал: М.Нурболат
Утас: 70007275 Цахим хаяг: lightanddelightaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ 3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ 5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА 13
4. АУДИТЫН ТАЙЛАН 17
4.1 Ерөнхий зүйл 17
4.2 Материаллаг байдал 17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт 17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал 17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 18
4.5.1 Завсрын аудитын талаар 18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал 19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ 20
5.1 Зөвлөмж 20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ 22

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

2025.02.24 № 171
танай ________ -ны № ________ -т

АЛТАЙ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА М.БАРШАГҮЛ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Алтай сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Алтай сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Алтай сумын Эрүүл мэндийн төв нь 2024 онд 1,403.8 сая төгрөгийн батлагдсан төсвөөр ажиллаж, гүйцэтгэлээр 1,225.6 сая төгрөг зарцуулж, 87.3 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь

832502000192

харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Алтай сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд тусгагдсан 1 зорилго, 4 зорилтын хүрээнд нийт 45 арга хэмжээ 85.6 хувийн биелэлттэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.АЙГУЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **218,439,420.41** | **452,627,100.08** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 45,870,413.08 | 964,332.96 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 45,870,413.08 | 964,332.96 |
| **3121** | **Төгрөг** | 45,870,413.08 | 964,332.96 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 45,870,413.08 | 964,332.96 |
| **33** | **АВЛАГА** | 17,611,008.00 | 266,807,090.79 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 17,611,008.00 | 266,807,090.79 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 154,957,999.33 | 184,855,676.33 |
| **351** | **Түүхий эд материал** | 92,765,545.33 | 100,010,016.33 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 23,651,330.00 | 24,996,330.00 |
| 35130 | Эм боох материал | 69,114,215.33 | 75,013,686.33 |
| **354** | **Хангамжийн материал** | 62,192,454.00 | 84,845,660.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 7,782,070.00 | 7,251,570.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 33,517,204.00 | 36,157,299.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 5,865,860.00 | 3,148,100.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 3,655,000.00 | 10,861,400.00 |
| 35460 | Хүнсний материал | 4,182,020.00 | 1,316,150.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 7,190,300.00 | 26,111,141.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **834,227,108.12** | **838,175,613.99** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 834,227,108.12 | 838,175,613.99 |
| **392** | **Биет хөрөнгө** | 828,866,308.12 | 832,264,813.99 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 648,576,800.00 | 648,576,800.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (56,204,861.70) | (68,237,835.66) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 114,549,996.00 | 112,341,665.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (62,301,163.82) | (62,741,140.02) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 246,824,957.00 | 270,433,745.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (97,325,785.03) | (119,535,921.16) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 49,040,535.00 | 54,285,125.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (14,294,169.33) | (12,857,624.17) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 15,751,993.00 | 10,000,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (15,751,993.00) | 00.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 5,360,800.00 | 5,910,800.00 |
| 39301 | Програм хангамж | 550,000.00 | 550,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (550,000.00) | 00.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 5,360,800.00 | 5,360,800.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,052,666,528.53** | **1,290,802,714.07** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,052,666,528.53** | **1,290,802,714.07** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,052,666,528.53 | 1,290,802,714.07 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 452,687,965.00 | 452,687,965.00 |
| 51101 | Өмч:- төрийн | 452,687,965.00 | 452,687,965.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 251,707,563.85 | 477,573,956.39 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 251,707,563.85 | 252,667,770.85 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 224,906,185.54 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 348,270,999.68 | 360,540,792.68 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,052,666,528.53** | **1,290,802,714.07** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **996,445,022.30** | **1,495,359,561.33** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **22,853,298.00** | **18,359,099.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 22,853,298.00 | 18,359,099.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 22,853,298.00 | 18,359,099.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,144,269.00 | 7,364,288.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 19,709,029.00 | 10,994,811.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **973,591,724.30** | **1,477,000,462.33** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 23,890,871.00 | 54,431,416.00 |
| 131005 | Хөрөнгийн санхүүжилт | 23,890,871.00 | 54,431,416.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 33,632,700.00 | 47,386,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 33,632,700.00 | 47,386,600.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 916,068,153.30 | 1,375,182,446.33 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 916,068,153.30 | 1,375,182,446.33 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **980,145,398.77** | **1,267,793,375.79** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **980,145,398.77** | **1,267,793,375.79** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 980,145,398.77 | 1,267,793,375.79 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 601,247,534.92 | 835,601,472.00 |
| 210101 | Үндсэн цалин | 388,575,769.00 | 504,132,792.00 |
| 210102 | Нэмэгдэл | 117,085,372.00 | 246,372,448.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,674,500.00 | 16,978,233.00 |
| 210104 | Урамшуулал | 89,911,893.92 | 68,117,999.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 74,322,833.00 | 103,555,580.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 51,389,533.00 | 70,618,151.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,733,400.00 | 8,140,874.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,586,500.00 | 4,389,226.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,146,600.00 | 4,221,557.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,466,800.00 | 16,185,772.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 30,748,500.00 | 44,502,400.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,394,700.00 | 3,394,700.00 |
| 210302 | Түлш, халаалт | 27,353,800.00 | 41,107,700.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 67,148,245.00 | 74,588,475.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,243,590.00 | 7,509,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 46,096,880.00 | 53,628,160.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,646,308.00 | 4,014,600.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,323,770.00 | 1,390,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 9,504,677.00 | 7,939,715.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 2,333,020.00 | 106,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 108,028,395.00 | 104,173,573.66 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 93,401,725.00 | 87,601,153.66 |
| 210502 | Хоол, хүнс | 14,235,170.00 | 16,572,420.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 391,500.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 14,600,680.00 | 12,923,900.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 139,600.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 14,461,080.00 | 12,923,900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,263,300.00 | 4,478,200.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,263,300.00 | 4,478,200.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,011,000.00 | 2,627,400.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 425,000.00 | 154,400.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 394,000.00 | 00.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 199,000.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,993,000.00 | 2,473,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 78,774,910.85 | 85,342,375.13 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,200,900.00 | 2,666,740.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 72,574,010.85 | 82,675,635.13 |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 00.00 | 2,660,000.00 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 00.00 | 2,660,000.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 00.00 | (2,660,000.00) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **16,299,623.53** | **224,906,185.54** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **935,234,114.30** | **1,180,737,251.54** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **3,144,269.00** | **7,364,288.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 3,144,269.00 | 7,364,288.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 3,144,269.00 | 7,364,288.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,144,269.00 | 7,364,288.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **932,089,845.30** | **1,173,372,963.54** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 33,632,700.00 | 47,386,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 33,632,700.00 | 47,386,600.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 898,457,145.30 | 1,125,986,363.54 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 898,457,145.30 | 1,125,986,363.54 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **914,048,682.92** | **1,205,061,331.66** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **914,048,682.92** | **1,205,061,331.66** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **914,048,682.92** | **1,205,061,331.66** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 601,927,825.92 | 835,601,472.00 |
| 210101 | Үндсэн цалин | 389,256,060.00 | 504,132,792.00 |
| 210102 | Нэмэгдэл | 117,085,372.00 | 246,372,448.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,674,500.00 | 16,978,233.00 |
| 210104 | Урамшуулал | 89,911,893.92 | 68,117,999.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 74,322,833.00 | 103,555,580.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 51,389,533.00 | 70,618,151.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,733,400.00 | 8,140,874.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,586,500.00 | 4,389,226.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,146,600.00 | 4,221,557.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,466,800.00 | 16,185,772.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 30,748,500.00 | 44,502,400.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,394,700.00 | 3,394,700.00 |
| 210302 | Түлш, халаалт | 27,353,800.00 | 41,107,700.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 71,362,200.00 | 70,032,410.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 7,605,500.00 | 3,755,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 48,299,200.00 | 51,661,300.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,835,300.00 | 3,954,600.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,151,000.00 | 1,476,750.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 10,471,200.00 | 9,184,760.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 96,290,516.00 | 103,288,129.66 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 74,369,316.00 | 88,236,579.66 |
| 210502 | Хоол, хүнс | 15,939,700.00 | 13,706,550.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 5,981,500.00 | 1,345,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 16,838,300.00 | 27,702,100.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,065,500.00 | 7,571,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 15,772,800.00 | 20,130,300.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,291,300.00 | 4,538,200.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,291,300.00 | 4,538,200.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 9,115,308.00 | 4,550,340.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 425,000.00 | 100,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 394,000.00 | 54,400.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 199,000.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 5,801,808.00 | 3,873,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210807 | Газрын төлбөр | 00.00 | 22,940.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 2,295,500.00 | 500,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 11,151,900.00 | 11,290,700.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,151,900.00 | 11,290,700.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **21,185,431.38** | **(24,324,080.12)** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **42,510,000.00** | **20,582,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **42,510,000.00** | **20,582,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 42,510,000.00 | 20,582,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 42,510,000.00 | 20,582,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(42,510,000.00)** | **(20,582,000.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | (21,324,568.62) | (44,906,080.12) |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 68,775,565.70 | 45,870,413.08 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 45,870,413.08 | 964,332.96 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 452,687,965.00 | 348,873,010.68 | 234,805,929.32 | 1,036,366,905.00 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 602,011.00 | 602,011.00 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **452,687,965.00** | **348,873,010.68** | **235,407,940.32** | 1,036,968,916.00 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 16,299,623.53 | 16,299,623.53 |
| **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **452,687,965.00** | **348,270,999.68** | **251,707,563.85** | 1,052,666,528.53 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 960,207.00 | 960,207.00 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **452,687,965.00** | **348,270,999.68** | **252,667,770.85** | 1,053,626,735.53 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт,бууралт | 00.00 | 12,269,793.00 | 00.00 | 12,269,793.00 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 224,906,185.54 | 224,906,185.54 |
| **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **452,687,965.00** | **360,540,792.68** | **477,573,956.39** | 1,290,802,714.07 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,403,785,600.00 | 1,225,643,331.66 | 178,142,268.34 | 87.3 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,403,785,600.00 | 1,225,643,331.66 | 178,142,268.34 | 87.3 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,403,785,600.00 | 1,225,643,331.66 | 178,142,268.34 | 87.3 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 939,337,500.00 | 835,601,472.00 | 103,736,028.00 | 89.0 |
| 210101 | Үндсэн цалин | 517,442,000.00 | 504,132,792.00 | 13,309,208.00 | 97.4 |
| 210102 | Нэмэгдэл | 286,167,100.00 | 246,372,448.00 | 39,794,652.00 | 86.1 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 30,240,000.00 | 16,978,233.00 | 13,261,767.00 | 56.1 |
| 210104 | Урамшуулал | 105,488,400.00 | 68,117,999.00 | 37,370,401.00 | 64.6 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 117,417,100.00 | 103,555,580.00 | 13,861,520.00 | 88.2 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 79,843,600.00 | 70,618,151.00 | 9,225,449.00 | 88.4 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,393,400.00 | 8,140,874.00 | 1,252,526.00 | 86.7 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,696,700.00 | 4,389,226.00 | 307,474.00 | 93.5 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,696,700.00 | 4,221,557.00 | 475,143.00 | 89.9 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 18,786,700.00 | 16,185,772.00 | 2,600,928.00 | 86.2 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 44,502,400.00 | 44,502,400.00 | - | 100.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,394,700.00 | 3,394,700.00 | - | 100.0 |
| 210302 | Түлш, халаалт | 41,107,700.00 | 41,107,700.00 | - | 100.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 75,660,200.00 | 70,032,410.00 | 5,627,790.00 | 92.6 |
| 210401 | Бичиг хэрэг | 7,012,600.00 | 3,755,000.00 | 3,257,600.00 | 53.5 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 51,661,300.00 | 51,661,300.00 | - | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,407,300.00 | 3,954,600.00 | 452,700.00 | 89.7 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,854,000.00 | 1,476,750.00 | 377,250.00 | 79.7 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 10,725,000.00 | 9,184,760.00 | 1,540,240.00 | 85.6 |
| **2105** | **Нормативт зардал** | 118,422,300.00 | 103,288,129.66 | 15,134,170.34 | 87.2 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 90,937,400.00 | 88,236,579.66 | 2,700,820.34 | 97.0 |
| 210502 | Хоол, хүнс | 18,998,700.00 | 13,706,550.00 | 5,292,150.00 | 72.1 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 8,486,200.00 | 1,345,000.00 | 7,141,200.00 | 15.8 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 72,424,400.00 | 46,967,100.00 | 25,457,300.00 | 64.8 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 18,299,600.00 | 16,266,800.00 | 2,032,800.00 | 88.9 |
| 210602 | Тавилга | 18,100,000.00 | 10,570,000.00 | 7,530,000.00 | 58.4 |
| 210604 | Урсгал засвар | 36,024,800.00 | 20,130,300.00 | 15,894,500.00 | 55.9 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 5,855,600.00 | 4,538,200.00 | 1,317,400.00 | 77.5 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,855,600.00 | 4,538,200.00 | 1,317,400.00 | 77.5 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 14,881,700.00 | 4,550,340.00 | 10,331,360.00 | 30.6 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,800,000.00 | - | 1,800,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 425,000.00 | 100,000.00 | 325,000.00 | 23.5 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 394,000.00 | 54,400.00 | 339,600.00 | 13.8 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 199,000.00 | - | 199,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 10,916,100.00 | 3,873,000.00 | 7,043,100.00 | 35.5 |
| 210807 | Газрын төлбөр | 50,700.00 | 22,940.00 | 27,760.00 | 45.2 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 1,096,900.00 | 500,000.00 | 596,900.00 | 45.6 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 15,284,400.00 | 12,607,700.00 | 2,676,700.00 | 82.5 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 15,284,400.00 | 12,607,700.00 | 2,676,700.00 | 82.5 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,403,785,600.00 | 1,180,737,251.54 | 223,048,348.46 | 84.1 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 47,386,600.00 | 47,386,600.00 | - | 100.0 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 47,386,600.00 | 47,386,600.00 | - | 100.0 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,356,399,000.00 | 1,125,986,363.54 | 230,412,636.46 | 83.0 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 1,356,399,000.00 | 1,125,986,363.54 | 230,412,636.46 | 83.0 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | - | 7,364,288.00 | (7,364,288.00) | - |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 7,364,288.00 | (7,364,288.00) | - |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **45,870,413.08** | **(45,870,413.08)** | **-** |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **964,332.96** | **(964,332.96)** | **-** |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 33.00 | 33.00 | - | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - | 100.0 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Алтай сумын ЭМТ-ийн эрхэм зорилго нь Хүн амын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан төрөөс анхан шатны болон үндсэн мэргэшлийн нэн шаардлагатай зарим тусламж үйлчилгээг иргэнд тэгш хүртээмжтэй, тасралтгүй, чанартай, цогц байдлаар үзүүлэхэд оршино.

ЗОРИЛТ: Байгууллагын бүтэц орон тоог оновчтой зохион байгуулж, хүний нөөцийг хөгжүүлэх, орчин үеийн тоног төхөөрөмжөөр ханган, материаллаг баазыг бэхжүүлэх, эм эмнэлгийн хэрэгслээр тасралтгүй хангах, холбогдох байгууллагуудтай мэдээлэл солилцоход цахим сүлжээг өргөнөөр ашиглах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд бүх нийтийг хамруулан, хэнийг ч орхигдуулахгүй байх.

Алтай сумын ЭМТ нь:
а.Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ

б. Эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Алтай сумын Эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай /Шинэчилсэн найруулга/
- Засгийн газрын 2024.02.28-ний өдрийн Тогтоолд хавсралт нэмэх, тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай 84 дүгээр тогтоол,
- Засгийн газрын 2024.03.27-ний өдрийн Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 128 дугаар тогтоол,
- Эрүүл мэндийн үндэсний зөвлөл (ЭМҮЗ)-ийн 2024 оны Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай 05 дугаар тогтоол,
- Эрүүл мэндийн үндэсний зөвлөл (ЭМҮЗ)-ийн 2024 оны Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай 06 дугаар тогтоол.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант хугацаанд мэргэжлийн байгууллагуудаас ямар нэгэн хяналт шалгалт хийгдээгүй байна.
Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Алтай сумын ЭМТ нь Сангийн сайдын тушаалаар баталсан Эрүүл мэндийн төвийн 2020 оны 06 дүгээр сарын 29-ны өдрийн А/18 тоот тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байна. Энэхүү нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинээр гарсан хууль эрхийн актуудтай нийцүүлэн шинэчлэх шаардлагатай байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Алтай сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 238,136.2 мянган төгрөгөөр буюу 22.6 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 45,870.4 | 964.3 | (44,906.1) |
| Авлага | 17,611.0 | 266,807.1 | 249,196.1 |
| Бараа материал | 154,958.0 | 184,855.7 | 29,897.7 |
| Үндсэн хөрөнгө | 834,227.1 | 838,175.6 | 3,948.5 |
| **Нийт хөрөнгө** | **1,052,666.5** | **1,290,802.7** | **238,136.2** |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 1,052,666.5 | 1,290,802.7 | 238,136.2 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **1,052,666.5** | **1,290,802.7** | **238,136.2** |

Өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан нь мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, эздийн өмчийн данс байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 964.3 мянган төгрөг болж 44,906.1 төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд 1,180,737.3 мянган төгрөгийн санхүүжилт авч 1,225,643.3 мянган төгрөгийг үйл ажиллагаанд зарцуулсантай холбоотой байна.

Авлагын дансны үлдэгдэл 266,807.1 мянган төгрөг болж 249,196.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд 1,375,182.4 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй ажиллаж, Эрүүл мэндийн даатгалын сангаас 1,125,986.3 мянган төгрөгийн санхүүжилт авч дутуу авсан санхүүжилттэй холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл 184,855.7мянган төгрөг болж 29,897.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд 9,954.1 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авч, урсгал санхүүжилтээс 198,218.6 мянган төгрөгийн худалдан авалт хийж, 178,275.1 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаанд зарцуулсантай холбоотой.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 838,175.6 мянган төгрөг болж, 3,948.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 55,472.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч, төсвийн хөрөнгөөр 20,582.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан, дахин үнэлгээний нэмэгдэл 13,230.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, 2,660.0 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй хөрөнгийг шилжүүлж, 82,675.6 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсонтой холбоотой.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 1,290,802.7 мянган төгрөг болж 238,136.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлан хугацаанд 224,906.2 мянган төгрөгийн үр дүнгээс гадна дахин үнэлгээний нэмэгдэл 13,230.0 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,173,372.0 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 7,364.0 мянга, нийт зарлагыг 1,225,643.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 835,601.0 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 103,555.0 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 44,502.0 мянга, хангамж, бараа материалын зардлыг 70,032.0 мянга, норматив зардлыг 103,288.0 мянга, эд хогшил, урсгал засварын зардлыг 46,967.0 мянга, томилолт, зочны зардлыг 4,538.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 4,520.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 12,607.0 мянга, бусад урсгал шилжүүлгийг 0 мянган төгрөгөөр бууруулж, 1,403,785.0 мянган төгрөгөөр баталсан нь төсвийн хэмнэлт гаргахыг зорьсонтой холбоотой байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71602 хөтөлбөрийн 80302, 81603 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,356,399.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 47,386.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр эрүүл мэндийн сангаас 1,125,986.4 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 47,386.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 7,364.3 мянган төгрөгөөр санхүүжиж, оны эхний үлдэгдлээс 45,870.4 мянган төгрөгийг зарцуулж, нийт 1,225,643.3 мянган төгрөгийн төсвөөр үйл ажиллагаа явуулсан байна. Зарцуулаагүй үлдсэн 964.3 мянган төгрөг байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,225,643.3 мянган төгрөг буюу 87.3 хувьтай байгаа нь нэг иргэнд ноогдох норматив төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх төсвийг 29,030.6 мянган төгрөг, үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээний төсвийг 149,111.6 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна. Зардлын эдийн засгийн ангиллаар цалин хөлс нэмэгдэл урамшуулал 103,736.0 мянган, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 13,861.5 мянга, хангамж, бараа материалын зардлыг 5,627.8 мянга, нормативт зардлыг 15,134.2 мянган, эд хогшил, урсгал засварын зардлыг 25,457.3 мянга, дотоод албан томилолт 1,317.4 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 10,331.4 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 2,676.7 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ | 1,356,399.0 | 1,178,256.8 | 178,142.2 | 86.9 |
| 1.1 | 80302 Нэг иргэнд ногдох нормативаар | 862,276.7 | 833,246.1 | 29,030.6 | 96.6 |
| 1.2 | 81603 Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ | 494,122.3 | 345,010.7 | 149,111.6 | 69.8 |
| 2 | 71601 Нийгмийн эрүүл мэнд | 47,386.6 | 47,386.6 | - | 100.0 |
| 2.1 | 80111 Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 47,386.6 | 47,386.6 | - | 100.0 |
| | **Нийт** | **1,403,785.6** | **1,218,279.1** | **185,506.5** | **86.8** |

Хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөсөн төсвийн гүйцэтгэл 86.8 хувийн биелэлттэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

2024 оны төсвийн жилд 198,218.6 мянган төгрөгийн бараа материал, 20,582.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авалтын хийсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Алтай сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотойгоор худалдан авалтыг хууль тогтоомжийн дагуу төлөвлөж зохион байгуулах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг "Лайт энд Дилайт Аудит" ХХК-ийн аудитор Л.Мөнхцэцэг гүйцэтгэж, аудитын менежер Ц.Төмөрсүх, компанийн захирал М.Нурболат нар анхан шатны чанарын хяналтыг, Баян-Өлгий аймаг дахь төрийн аудитын газрын аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Алтай сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймгийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайланг, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 980,145.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 14,702.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллаа явуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 29 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлсэн. Алдаа, зөрчил илрээгүй.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн 2 зөрчилд зөвлөмж өглөө.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 14 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих нийт 191 мэдээллээс 132 мэдээллийг хугацаанд нь байршуулсан ба Шилэн дансны цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш нийт 68 удаагийн 1,260,040.3 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээ мэдээлэхээс 65 удаагийн 1,240,665.0 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээг хугацаа хоцроосон ба шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 95.5 хувьтай байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2 заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй мэдээллийг нөхөж байршуулан зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүллээ.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар эхний хагас жилийн санхүүгийн тайланд аудит хийж, байгууллага, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт олж авав эрсдэл тодорхойлж, аудитын ерөнхий стратеги боловсруулсан.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчилгүй байна.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Энэхүү аудитаар цэцэрлэгийн өмч хөрөнгийн хадгалалт, ашиглалт, төсвийн зарцуулалтыг бүрэн шалгах боломжгүй тул эрсдэлтэй гэж сонгосон данс, ажил гүйлгээнүүдэд горим сорил хэрэгжүүлсэн.

Гүйцэтгэлийн шалгалтаар өмч хөрөнгийн хадгалалт, ашиглалт, төсвийн зарцуулалтыг дэлгэрэнгүй шалгах шаардлагатай гэж үзэв.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой алдаа[1] илрээгүй болно.

Аудитаар нийт 48,299.2 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс цаашид давтан гаргахгүй ажиллах 2 зөвлөмж өгч ажилласан.

### 5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд: нь

**1. *Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилттэй холбоотой асуудал***

*Илрүүлэлт:* Тайлант хугацаанд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлээгүй, шууд худдалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (ТБОНӨБАҮХАТ)-ийн 44 дүгээр зүйлийн 44.1 "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", 10 дугаар зүйлийн 10.3 "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", 10.5 "Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар багцалж болно", 45 дугаар зүйлийн 45.3. "Энэ хуулийн 45.2-т заасан жагсаалтад хамаарахгүй улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлэх өөрийн хэрэгцээнд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хувьд төсвийн шууд захирагч захиалагч байна", Засгийн газрын 2025 оны "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" тогтоолоор батлагдсан “"Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар”-ыг тус тус зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлж ажиллах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор,зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Тайлант хугацаанд батлагдсан 48,299.2 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй тээвэр шатахуун худалдан авалт хийхдээ худалдан авалтын төлөвлөгөө боловсруулаагүй, шууд худалдан авалт хийсэн байна. | 1 | 48,299.2 | - | - | - | - | 1 | 48,299.2 | - | - | - | - |
| | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| **ДҮН** | **1** | **48,299.2** | **-** | **-** | **-** | **-** | **1** | **48,299.** | **-** | **-** | **-** | **-** |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | | |
| Шилэн дансны цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш нийт 68 удаагийн 1,260,040.3 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээ мэдээлэхээс 65 удаагийн 1,240,665.0 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээг хугацаа хоцроосон байна. | 1 | 1,240,665.0 | - | - | - | - | 1 | 1,240,665.0 |
| | - | - | - | - | - | - | - | - |
| **ДҮН** | **1** | **1,240,665.0** | **-** | **-** | **-** | **-** | **1** | **1,240,665.0** |